ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 3 (384)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- *Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*
- *Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- *Бичиг үсгийн боловсролын үндэсний хөтөлбөр батлах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар
Улаанбаатар хот
2005 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ
Долоо хоног тутмын
Улаанбаатар хот 2005 оны нэгдүгээр сарын 21 №3 (384)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

504. Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай . 58
505. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай 61

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

506. Үндсэн хуулийн цэцийн гишүүнээс чөлөөлөх тухай Дугаар 01 61
507. Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг томилох тухай Дугаар 02 61
508. Байгаль орчны талаар авах зарим арга хэмжээний тухай Дугаар 03 62
509. Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай Дугаар 04 62

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

510. Хүнс, хөдөө аж ахуйн яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг зөвшөөрч, зохион байгуулалтын бүтцийг батлах тухай Дугаар 243 63
511. Бичиг үсгийн боловсролын үндэсний хөтөлбөр батлах тухай Дугаар 244 72

2005 оны 1 дүгээр сарын 13–ны өдөр

Улаанбаатар хот

ГАМШГААС ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 25, 29, 32, 33 дугаар зүйл, 4.1, 17.1, 23.1, 24.1, 27.1 дэх хэсэгт дор дурдсан агуулгатай хэсэг, заалт нэмсүгэй:

1/ 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 14, 15, 16, 17 дахь заалт:

"4.1.14. "онцгой байдал" гэж гамшгаас хамгаалах арга хэмжээ авах, түүнийг хэрэгжүүлэхэд төрийн захиргааны төв болон бусад байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтны үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх зэрэг онцгой ажиллагаа явуулж байгаа нөхцлийг;

4.1.15. "аврах ажиллагаа" гэж гамшгийн аюулын үед хүн, мал, амьтан, эд хөрөнгө, түүх, соёлын дурсгалт зүйлийг эрж хайх, аврах, гал түймрийн шаталтыг зогсоох, унтраах, нэрвэгдэгсдэд анхны тусламж үзүүлэх, гамшгийн голомтоос гаргах, хор уршигийг арилгах үйл ажиллагааг;

4.1.16. "гамшгаас хамгаалах улсын хяналт" гэж гамшгаас хамгаалах тухай хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, заавар, норм, нормативын хэрэгжилтэд хяналт тавихыг;

4.1.17. "аврагч" гэж аврах ажиллагааны арга технологийг эзэмшиж, мэргэжлийнхээ дагуу онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллага, аврах болон мэргэжлийн ангид ажиллаж байгаа мэргэшсэн албан хаагчийг."

2/ 17 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 9, 10, 11 дэх заалт:

"17.1.9. Зам, тээврийн алба;
17.1.10. Барилга, хот байгуулалтын алба;
17.1.11. Мэргэжлийн хяналтын алба."

3/ 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт:

"23.1.6. гамшгийн цагийн байдлын талаар Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдад шуурхай мэдээлж байх."

4/ 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 14 дэх заалт:

"24.1.14. гамшгаас хамгаалах тухай мэдээлэл, сурталчилгаг хэвлэл, мэдээллийн байгууллагаар дамжуулан олон нийтэд хүргэх;"

5/ 25 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

"25.3. Гамшгаас хамгаалах улсын хяналтын ерөнхий байцаагч нь онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга байна."

6/ 27 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт:

"27.1.10. гамшгаас хамгаалах тухай мэдээлэл, сурталчилгаг холбоо болон хэвлэл, мэдээллийн хэрэгслээр үнэ төлбөргүй шуурхай дамжуулж, олон нийтэд хүргэх."

7/ 29 дүгээр зүйлийн 3, 4 дэх хэсэг:

"29.3. Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын тусгай албан тушаал эрхэлдэг албан хаагч нь төрийн албанд анх орохдоо 'Монгол Улсын иргэн би онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагад ажиллахдаа төрийн хүүпийг дээдлэн, хүлээсэн үүргэг үнэнч шударгаар биелүүлж, шаардлага гарвал амь насаа ул хайрлан тэмцэхээ батлан тангараглая. Би энэ тангарагаас няцваас холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээнэ" хэмээн тангараг өргөнө.

29.4. Энэ хуулийн 29.3-т заасан тангараг өргөх журмыг Монгол Улсын Ерөнхийлөгч тогтооно."

8/ 32 дугаар зүйлийн 2, 4 дэх хэсэг:

"32.2. Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын тусгай алба хаагч ахлагч нь шадар түрүүч, тэргүүн түрүүч, дэд түрүүч, офицер нь шадар дэслэгч, тэргүүн дэслэгч, дэд дэслэгч, шадар ахмад, тэргүүн ахмад, дэд ахмад, комиссар, тэргүүн комиссар гэсэн цолтой байна.

32.4. Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын тусгай албан тушаал эрхэлдэг албан хаагчийн алба хаах журмыг асуудал эрхэлсэн сайд батлана."

9/ 33 дугаар зүйлийн 8, 9, 10, 11, 12, 13 дахь хэсэг:

"33.8. Энэ хуулийн 33.7.1-д заасан ілингийн зөрүүг тахир дутуугийн тэтгэвэр авч ійгаа хугацаанд олгоно.

33.9. Онцгой байдлын асуудал эрхэлсэн ійгууллагын тусгай албан тушаал эрхэлдэг албан іагчийг цэргийн жинхэнэ албанд татахаас ілөөлнө.

33.10. Онцгой байдлын асуудал эрхэлсэн ійгууллагын тусгай албан тушаал эрхэлдэг албан ігчийн ажилдаа ирэх, буцах болон байгууллагын дна албан үүргэг биелүүлэхийг албаны үүргээ ідцэтгэж байгаад тооцно.

33.11. Онцгой байдлын асуудал эрхэлсэн ійгууллагын тусгай албан тушаал эрхэлдэг албан ігчид цалин, хөлс олгох журмыг Засгийн газар ітооно.

33.12. Аврах ажиллагааны оролцдог албан ігч дараахь нэмэлт хөнгөлөлт, урамшууллыг ілнэ:

33.12.1. аврах ажиллагаа явуулсны ілөө урамшуулал авах. Урамшуулал олгох журмыг ігийн болон Онцгой байдлын асуудал эрхэлсэн ійдын хамтарсан тушаалаар тогтооно;

33.12.2. алба хаасан хугацааг нь ітооход ажилласан нэг жилийг нэг жил гурван ібаар тооцох;

33.12.3. жил бүр ажлын 20 өдрийн ілжийн амралт эдлэх;

33.12.4. алба хаасан таван жил тутамд 3 ійн нэмэгдэл амралт эдлэх;

33.12.5. гамшгийн голомтод ілласан тохиолдолд эмнэлгийн үзлэгт ілрагдаж, шаардлагатай бол нөхөн сэргээх ічилгээ хийлгэх;

33.12.6. үйлдвэрлэлийн осол, ргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд ітгуулах бөгөөд зардлыг тэр хариуцах.

33.13. Энэ хуульд зааснаас бусад ігөлөлт, урамшууллын төрөл, хэмжээг Засгийн ар тогтоож болно."

2 дугаар зүйл. Гамшгаас хамгаалах тухай ілийн 4.1.4-ийн "тээврийн хэрэгсэл" гэсний дараа ілдох," гэж; 7.3.5-ын "оюутан, сурагчдын" гэсний ібаа "гамшгаас хамгаалах боловсрол олгох" гэж; 12, 11.3, 11.4-ийн "гамшгийн" гэсний дараа ізулын" гэж; 22.1.1-ийн "хамгаалах" гэсний дараа ійн бодлого," гэж; 24.1.1-ийн "Засгийн газрын ній дараа "болон Онцгой байдлын асуудал эрхэлсэн сайдын" гэж; 27.1.8-ын "тохируулж" гэсний дараа "энэ хуулийн 27.1.2-т заасан" гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Гамшгаас хамгаалах тухай хуулийн дараахь хэсэг, заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

"3.1. Энэ хууль нь гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгоход гамшгаас хамгаалах алба, бусад байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтны үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах, уялдуулан зохицуулах, гамшгаас хамгаалах улсын хяналтыг хэрэгжүүлэх хүрээнд үйлчилнэ."

2/ 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт:

"4.1.2. "гамшиг" гэж аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол, алан хядах ажиллагаа, дэлбэрэлтийн улмаас олон хүний эрүүл мэнд, амь нас хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд улс, орон нутгийн дотоод нөөц боломжоос давсан хохирол учрахыг;"

3/ 7 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 1 дэх заалт:

"7.3.1. онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагч, уг байгууллагын харьяа нэгж болон аймаг, нийслэлийн онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллага, гамшгаас хамгаалах албаны удирдах бүрэлдэхүүний сургалтыг онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага;"

4/ 9 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг:

"9.6. Энэ хуулийн 9.5.2, 9.5.3-т заасан шийдвэрийг доод шатны Засаг даргын санал болон онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дүгнэлт, асуудал эрхэлсэн сайдын саналыг үндэслэн гаргана."

5/ 13 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

"13.2. Улсын хэмжээнд гамшгаас хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх үүрэгтэй онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэл, дүүргэт онцгой байдлын асуудал эрхэлсэн газар, хэлтэс байна. Онцгой байдлын асуудал эрхэлсэн газар, хэлтэс нь орон нутагт гамшгаас хамгаалах арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулах, хэрэгжүүлэхэд аж ахуйн нэгж,

байгууллага, албан тушаалтан, иргэдийн үйл ажиллагаег уялдуулан зохицуулна. Суманд онцгой байдлын асуудал хариуцсан орон тооны бус штаб ажиллана."

6/ 20 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

"20.1. Гамшгаас хамгаалах хүч хэрэгсэл нь онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллага, гамшгаас хамгаалах чиг үүрэг бүхий албад, аж ахуйн нэгж, байгууллага, мэргэжлийн анги болон сайн дурынхан байна."

7/ 21 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг:

"21.3. Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга нь байгууллагын харьяа нэгжийн зохион байгуулалтын бүтэц, орон тоог батална."

8/ 22 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт:

"22.1.2. гамшгаас хамгаалах улсын хяналтын дүрмийг батлах."

9/ 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт:

"23.1.5. улсын болон гамшгаас хамгаалах нөөцийг зохих журмын дагуу захиран зарцуулах, нөхөн бүрдүүлэх."

10/ 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2, 9 дэх заалт:

"25.1.2. гамшгийн цагийн байдлын талаар онцгой байдлын асуудал эрхэлсэн сайдад шуурхай мэдээлэх;

25.1.9. батлагдсан төсөв болон асуудал эрхэлсэн сайдын баталсан зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарт багтаан байгууллагын орон тоо, цалингийн санг тогтоох;"

11/ 33 дугаар зүйлийн 7 дахь хэсэг:

"33.7. Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын тусгай албан тушаал эрхэлдэг албан хаагч албан үүргээ гүйцэтгэх үед эрүүл мэнд нь хохирсон, эсхүл амь насаа алдсан тохиолдолд түүнд болон түүний ар гэрт дор дурдсан тэтгэвэр, тэтгэмж олгоно:

33.7.1. хөдөлмөрийн чадвараа тур алдсан, тахир дутуу болсон тохиолдолд тэтгэвэр, тэтгэмж болон авч байсан албан тушаалын үндсэн цалингийн зөрүү;

33.7.2. химэл эрхтэн хийгдсэн тохиолдолд түүний зардал;

33.7.3. амь насаа алдсан тохиолдолд ар гэрт нь түүний 5 жилийн үндсэн цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмж."

4 дүгээр зүйл. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 1.1, 6.1, 6.2, 8.1, 8.4.2-ын "гамшгаас хамгаалах байгууллага, алба" гэснийг тохиолдол бүрт нийцүүлэн "онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллага болон гамшгаас хамгаалах алба" гэж; 6 дугаар бүлэг, 29, 30, 31, 32, 33, 34 дүгээр зүйл, 29.1, 29.2, 30.1, 30.2, 31.1, 31.2, 32.1, 33.1-33.6, 34.1, 34.2, 31.1.4-ийн "гамшгаас хамгаалах байгууллага" гэснийг тохиолдол бүрт нийцүүлэн "онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллага" гэж; 15, 24, 25 дугаар зүйл, 7.4, 11.1, 11.6, 12.1, 14.1, 15.1-15.7, 25.1, 25.2, 29.1, 33.5, 8.2.7, 10.1.3, 18.1.8, 25.1.7, 25.1.11, 26.1.5-ын "гамшгаас хамгаалах асуудал эрхэлсэн" гэснийг тохиолдол бүрт нийцүүлэн "онцгой байдлын асуудал эрхэлсэн" гэж; 19 дүгээр зүйл, 11.6, 19.1-19.5, 25.1.1-ийн "шуурхай штаб" гэснийг "шуурхай бүлэг" гэж; 14.1-ийн "Монгол Улсын Ерөнхий сайд", 23 дугаар зүйл, 19.2, 23.1-ийн "Ерөнхий сайдын" гэснийг тохиолдол бүрт нийцүүлэн "Онцгой байдлын асуудал эрхэлсэн сайд" гэж; 15.6, 31.2-ын "Засгийн газар" гэснийг "Онцгой байдлын асуудал эрхэлсэн сайд" гэж; 16.2, 17.2-ын "Ерөнхий сайд" гэснийг "Засгийн газар" гэж; 17.1.4-ийн "Дэд бүтцийн" гэснийг "Түлш, эрчим хүчний" гэж; 17.1.6-гийн "Сурталчилгаа, мэдээллийн" гэснийг "Сурталчилгааны" гэж; 17.1.7-гийн "Гал түймэртэй тэмцах" гэснийг "Мэдээлэл, харилцаа, холбооны" гэж; 24.1.8, 25.1.4-ийн "Ерөнхий сайдын" гэснийг "Засгийн газар, Онцгой байдлын асуудал эрхэлсэн сайдын" гэж; 25.1.1-ийн "төлөвлөж хэрэгжүүлэх" гэснийг "мэргэжлийн удирдлагаар хангах" гэж; 32.2 дахь хэсгийн дугаарыг "32.3" гэж; 24.1.14 дэх заалтын дугаарыг "24.1.15" гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4.1.4-ийн "томоохон", 7.1-ийн "холбогдох", 8.4.2-ын "тэдгээрийн штаб, аврах анги, отряд, салбар", 23.2-ын "Ерөнхий сайдын дэргэд" гэснийг тус тус хассугай.

6 дугаар зүйл. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 15.3, 15.4 дэх хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДЭД
ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

)05 оны 1 дүгээр
рын 13–ны өдөр

Улаанбаатар
хот

ЗАХИРГААНЫ ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Захиргааны хэрэг хянан
йдвэрлэх тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3
ıхь хэсгийн "шийдвэрлэх ба санал тэнцвэл
хуралдаан даргалагчийн саналаар" гэснийг хассугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

)05 оны 1 дүгээр
рын 13–ны өдөр

Дугаар 01

Улаанбаатар
хот

Үндсэн хуулийн цэцийн гишүүнээс чөлөөлөх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран
дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын
дсэн хуулийн цэцийн тухай хуулийн 4 дүгээр
лийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их
элаас ТОГТООХ нь:

1.Бүрэн эрхийн нь хугацаа дуусгавар
сон тул Жүгнээгийн Амарсанаа, Жигжидийн
лдбаатар, Наваанпэрэнлэйн Жанцан, Ванчигийн
эал нарыг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн
үүнээс тус тус чөлөөлсүгэй.

2.Энэ тогтоолыг 2005 оны 1 дүгээр сарын
13-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

05 оны 1 дүгээр
рын 13–ны өдөр

Дугаар 02

Улаанбаатар
хот

Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран
дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, Монгол Улсын
дсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар
лийн 1 дэх хэсэг, 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг,
ал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их
элаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Ерөнхийлөгчийн санал
лгосноор Жигжидийн Болдбаатар,
наанпэрэнлэйн Жанцан нарыг, Монгол Улсын
д шүүхийн санал болгосноор Жүгнээгийн
эрсанаагаа Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр тус
томилсугай.

2.Энэ тогтоолыг 2005 оны 1 дүгээр сарын
13-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2005 оны 1 дүгээр сарын 13–ны өдөр | Дугаар 03 | Улаанбаатар хот

Байгаль орчны талаар авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн Байгаль орчны төлөв байдлын 2003 оны тайлангийн тухай хэлэлцээд Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Байгаль орчны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр дор дурдсан арга хэмжээ авахыг Монгол Улсын Засгийн газар /Ц.Элбэгдорж/-т даалгасугай :

1/Байгаль, цаг уурын өөрчлөлт, хүний хууль бус үйл ажиллагааны улмаас тархац, нөөц нь эрс багассан зарим амьтан, ургамал, ялангуяа мазаалай баавгай, хавтгай тэмээ, цоохор ирвэс, халиун буга, баданга худэр, монгол бөхөн болон экосистемд онцгой үүрэг бүхий тарвага, цагаан зээр зэрэг амьтад, эдийн засгийн өндөр ашигтай, ховордсон ургамлыг хамгаалах тусгай хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх, энэ чиглэлээр олон улсын байгууллагын дэмжлэг, туслалцаанд хамрагдах арга хэмжээ авах;

2/Туймэр, ойн хөнөөлт шавьж, өвчинд нэрвэгдсэн болон зүй бус ашиглалтад хүчтэй өртсөн ойг нөхөн сэргээх, ой модны хулгайг таслан зогсоохад чиглэгдсэн төрийн нэгдсэн бодлого, эрх зүйн зохицуулалтын асуудлыг боловсруулан шийдвэрлэх, хэрэгжүүлэх арга хэмжээ авах;

3/Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах, хог хаягдлыг багасгах, гүний усны хайгуул, судалгаа, гадаргын усны ашиглалтыг нэмэгдүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээг тусгасан мастер төлөвлөгөө боловсруулж, шийдвэрлэн хэрэгжүүлэх;

4/Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөжүүлэх, тэдгээрийн хамгаалалтын захиргаадыг бэхжүүлэх, уг бүс нутагт хууль бусаар ашигт малтмал олборлох үйл ажиллагаа явуулж байгааг таслан зогсоох арга хэмжээ авч, энэ чиглэлээр төв, орон нутгийн байгууллага, иргэдийн ажлын уялдаг хангах;

5/Байгаль орчны чиглэлээр мөрдөгдөж байгаа хууль тогтоомж, эрх зүйн орчныг цогц байдлаар боловсронгуй болгох, ялангуяа агаар, усыг бохирдуулсны, байгалийн бусад нөөц баяжлийг ашигласны орлогоос байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхэд зарцуулах болон байгаль хамгаалагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхтэй холбогдсон хууль эрх зүйн орчныг эхний ээлжинд бүй болгож мөрдүүлэх;

6/ Улс орны хөгжлийн хэтийн төлөв, чиг хандлагад байгаль, цаг уурын өөрчлөлтийн нөлөөллийг урьдчилан тогтоож, байгалийн нөөц, даацтай уялдуулсан төрийн бодлогыг хэрэгжүүлэх.

2. Энэхүү тогтоолын хэрэгжилтийн явцыг 2006 оны эхний хагас жилд багтаан Улсын Их Хуралд танилцуулсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2005 оны 1 дүгээр сарын 13–ны өдөр | Дугаар 04 | Улаанбаатар хот

Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай

Засгийн газрын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Төрийн захиргааны байгуллагын тогтолцоо, бүтцийн өөрчлөлт бүдүүвчийг батлах тухай Улсын Их Хурлын 2004 оны 14 дүгээр тогтоолын хавсралтын Монгол Улсын сайдын эрхлэх асуудлын хүрээнд "11. Гамшгаас хамгаалах өөрчлөлт газар" гэснийг "11. Онцгой байдлын өөрчлөлт газар" гэж өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 12 дугаар сарын 22–ны өдөр | Дугаар 243 | Улаанбаатар хот

Хүнс, хөдөө аж ахуйн яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг зөвшөөрч, зохион байгуулалтын бүтцийг батлах тухай

Засгийн газрын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 10.1-ийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Хүнс, хөдөө аж ахуйн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг хавсралт ёсоор зөвшөөрсүгэй.

2.Хүнс, хөдөө аж ахуйн яамны зохион байгуулалтын бүтцийг дор дурдсанаар батлсугай:

1/Стратегийн бодлого, төлөвлөлтийн газар /стратегийн бодлогын хэлтэс, хөдөө аж ахуйн тусгай зориулалтын сангийн хэлтэс, төлөвлөлт, санхүүгийн хэлтэстэй/;

2/Төрийн захиргааны удирдлагын газар;

3/Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /мал аж ахуйн хэлтэс, газар тариалан, техник, технологийн хэлтэс, хүнсний хэлтэс, бэлчээр-тариалангийн усжуулалтын хэлтэстэй/;

4/Мэдээлэл,хяналт-шинжилгээ, үнэлгээний газар;

5/Мал эмнэлгийн газар;

6/Гадаад хамтын ажиллагааны хэлтэс.

3. Хүнс, хөдөө аж ахуйн яамны орон тооны хязгаарыг 72 хүнээр, зардлын төсвийн хязгаарыг 602701.5 /зургаан зуун хоёр сая долоон зуун нэг мянга таван зуун/ мянган төгрөгөөр, цалингийн сангийн хязгаарыг 126668.5 /нэг зуун хорин зургаан сая зургаан зуун жаран найман мянга таван зуун/ мянган төгрөгөөр тогтоосугай.

4 .Энэ тогтоол гарсантай холбогдуулан Засгийн газрын 2002 оны 8 дугаар сарын 14-ний өдрийн 162 дугаар тогтоолын хавсралтаар батлсан «Монгол Улсын Засгийн газрын тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлагийн жагсаалт»-ын 31 дэх заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Ц.ЭЛБЭГДОРЖ

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЙД Д. ТЭРБИШДАГВА

Засгийн газрын 2004 оны 243 дугаар тогтоолын хавсралт

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ, БҮТЦИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ХӨТӨЛБӨР

1. Нийтлэг үндэслэл

1.1. Оршил

Хүнс, хөдөө аж ахуйн яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр /цаашид "хөтөлбөр" гэх/-т Засгийн газрын Ганхим, Хүнс, хөдөө аж ахуйн сайдаас хүнс, хөдөө аж ахуйн салбарын асуудлаар шийдвэр гаргах, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамж, төрийн захиргааны удирдлага зохицуулалтаар хангах, бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ /мониторинг/ хийх, үнэлгээ өгөх асуудлыг хамарсан Хүнс, хөдөө аж ахуйн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн загварыг тодорхойлов.

1.2. Үндэслэл

Хөтөлбөрийг Засгийн газрын тухай хууль, Засгийн газрын бүтцийн тухай хууль, Яамны эрх зүйн байдлын тухай хууль, Улсын Их Хурлын 1996 оны 38 дугаар тогтоолоор зөвшөөрсөн "Монгол Улсын төрөөс Засгийн газрын үйл ажиллагааны чиглэл, бүтцийн ерөнхий тогтолцооны өөрчлөлт, шинэчлэлийн талаар баримтлах бодлого"-ын баримт бичиг, Засгийн газрын Удирдлагын хөгжлийн хөтөлбөрийн "Төрийн захиргаа, төрийн албаны өөрчлөлт шинэчлэл" бүрэлдэхүүн хэсгийн МОН/94/102 тесийн хүрээнд боловсруулсан "Хөдөө аж ахуй, үйлдвэрийн яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн ерөнхий загвар" тесийн тайлан, Хүнс, хөдөө аж ахуйн яамны үйл ажиллагааны хэтийн

төлөвлөгөө зэрэг баримт бичгүүдийг тус тус үндэслэн боловсруулав.

1.3. Эрх зүйн орчин

Хөтөлбөрийг дор дурдсан хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлнэ:

- Монгол Улсын Үндсэн хууль;
- Засгийн газрын тухай хууль;
- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль;
- Төрийн албаны тухай хууль;
- Хөдөлмөрийн тухай хууль;
- Төсвийн байгуллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль;
- Яамны эрх зүйн байдлын тухай хууль;
- Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хууль;
- Газрын тухай хууль;
- Газрын төлбөрийн тухай хууль;
- Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль;
- Хүнсний тухай хууль;
- Тариалангийн тухай хууль;
- Таримал ургамлын үр, сортын тухай хууль;
- Үрийн тариалангийн даатгалын тухай хууль;
- Эмийн тухай хууль;
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль;
- Усны тухай хууль;
- Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль;
- Хоршооны тухай хууль;
- Бусад хууль тогтоомж.

1.4. Арга зүй

Хөтөлбөрийг боловсруулахдаа олон улсын туршлага, өөрчлөлтийн удирдлага, үйл ажиллагаа /бизнес/-ны төлөвлөлт болон дахин инженерчлэл, байгуллагын өөрчлөлтийн онол зэрэг арга зүйг хэрэглэв.

1.5. Чиглэлийн яамны үүрэг хариуцлагын ерөнхий хуваарь

Хүнс, хөдөө аж ахуйн яам нь Засгийн газрын үйл ажиллагааны хүнс, хөдөө аж ахуйн салбарын зорилтыг хэрэгжүүлэх чиг үүргийг дагнан эрхэлсэн төрийн захиргааны төв байгуллага болохын хувьд Хүнс, хөдөө аж ахуйн сайд, Засгийн газрын Танхимд бүх талын зөвлөгөө, дэмжлэг үзүүлж, Засгийн газрын хүнс, хөдөө аж ахуйн зөвлөхийн үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Хүнс, хөдөө аж ахуйн яам нь салбарын бодлогын төлөвлөлт, төсвийн зарцуулалт, хаврилцан уялдаа холбоог хангах асуудалд өөрөн хүрээтэй хандаж, зөв зохистой удирдана.

Яам нь хүнс, хөдөө аж ахуйн салбарын хэтийн болон дунд хугацааны стратегийн төлөвлөгөө, үндсэн чиглэл, төсвийн төслийг боловсруулах, төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг хангуулах, хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, чиглэлийг тодорхойлсон үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөтэй ажиллана.

1.6. Стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр

Хүнс, хөдөө аж ахуйн яамны стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр болон үндсэн үйлчлүүлэгч, хэрэгцэгчийг зөв тодорхойлох нь тус яамны үйл ажиллагааны стратегийг үндэслэл сайтай тогтооход чухал ач холбогдолтой юм. Энэ хэрэгцээний эх үүсвэрт дор дурдсан үйлчлүүлэгч бүюу хэрэглэгч хамрагдана:

Хүнс, хөдөө аж ахуйн яамны стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр

Хүнс, хөдөө аж ахуйн яамны үндсэн
йлчлүүлэгч буюу хэрэглэгч нь Хүнс, хөдөө аж
хуйн сайд, Засгийн газрын Танхим байна.

Стратегийн удирдлага, зохицуулалтын
эрэгцээг хангах үйлчилгээний хүрээ, төрөл,
элбэрийг үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгч,
эрэгцээний эх үүсвэр тус бүрээр тогтоон яамны
охион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн чиг үүрэг,
өрийн албан хаагчдын ажлын байр /албан тушаал/
ны тодорхойлолтод нарийвчлан тусгаж
эрэгжүүлнэ.

2. Хүнс, хөдөө аж ахуйн яамны үйл
ажиллагааны стратеги

2.1. Үйл ажиллагааны стратегийн мөн
анар

Хүнс, хөдөө аж ахуйн яамны үйл
ажиллагааны стратегийн мөн чанар нь Засгийн
эзрын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл, Засгийн
эзрын үйл ажиллагааны хөтөлбөр, Хүнс, хөдөө аж
хуйн сайдын эрхлэх асуудлын зорилт, чиг үүргийг
эрэгжүүлэхэд чиглэсэн Хүнс, хөдөө аж ахуйн
айдын үйл ажиллагаанд өндөр мэргэшлийн, цаг
ез олсон, шуурхай зөвлөлгөө, бүх талын дэмжлэг
зүүлэхэд оршино.

2.2. Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл

Хүнс, хөдөө аж ахуйн яам нь дор дурдсан
йл ажиллагааны тэргүүлэх чиглэлтэй ажиллана:

2.2.1. Удирдлагын орчин үеийн дэвшилтэт
рга барил, туршлагыг нэвтрүүлэх, үндэсний
ехнологийг хөгжүүлэх, шинжлэх ухааны ололт,
инэ бүтээлийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх;

2.2.2. Хүнс, хөдөө аж ахуйн салбарт өмчийн
ух хэлбэрийн хуулийн этгээдийг дэмжиж, аж ахуйн
эгжийн менежментийг сайжруулж өрсөлдөх
эдвараг дээшлүүлэх;

2.2.3. Хөдөө аж ахуйн эдэлбэр газрыг
охистой ашиглах, нөхөн сэргээх болон бэлчээрийн
ваацыг нэмэгдүүлэх, үсжүулах арга хэмжээг
эгөжүүлэн, уст цэгийн ашиглалт, ээмшилтийг
эйжруулах;

2.2.4. Малын тоог өсгөн, сүргийн чанарыг
эйжруулж, удмын санг хамгаалахын зэрэгцээ мал
ргийг байгалийн гамшгаас сэргийлэх, хүнс, хөдөө
ж ахуйн гаралтай түүхий эдийн экспортыг
эмэгдүүлэх;

2.2.5. Мал, амьтны халдварт, паразиттах
ачнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх арга
хэмжээний үр дүнг дээшлүүлж, өвчний тархалт
гаралтыг тогтвортой бууруулах;

2.2.6. Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн
техник, технологийг шинэчлэн, эрчимжилт
нэвтрүүлэх, хүнсний хангамжийг нэмэгдүүлж
хэрэглээний аюулгүй байдлыг хангах;

2.2.7. Хоршоо, фермерийн аж ахуйг
хөгжүүлэх саналчилга хөдөлгөөнийг өрнүүлж
ядуурлыг бууруулах, ажлын байр бий болгох,
үйлчилгээний хүрээг өргөтгөх чиглэлээр хоршоо
байгуулахад тал бүрийн дэмжлэг туслалцаа
үзүүлэх;

2.2.8. Орон нутгийн зээлийн чадавхийг
нэмэгдүүлж гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих,
хүнс, хөдөө аж ахуйн менежментийг сайжруулан
хүний нөөцийн манлайллыг хангах.

2.3. Байгуллагын алсын хараа

Дотоод, гадаадын зах зээлд өрсөлдөх
чадвартай, байгалийн болон эдийн засгийн эрсдэл
даах эрчимжсэн хүнс, хөдөө аж ахуйн салбарыг
төлөвшүүлэх.

2.4. Үйл ажиллагааны эрхэм зорилго

Хүнс, хөдөө аж ахуйн яамны үйл
ажиллагааны эрхэм зорилго нь эдийн засгийн
өсөлтийг хангахуйц бүс нутгийн болон хөдөөгийн
хөгжлийг дэмжиж, хүнс, хөдөө аж ахуйн салбарын
тогтвортой хөгжлийн таатай орчин бүрдүүлэх явдал
мөн.

2.5. Үйл ажиллагааны стратегийн зорилт

Хүнс, хөдөө аж ахуйн яам нь үйл
ажиллагааныхаа эрхэм зорилгынхоо хүрээнд үйл
ажиллагааны стратегийн дор дурдсан зорилтыг
хэрэгжүүлнэ:

2.5.1. Хүнс, хөдөө аж ахуйн сайдын эрхлэх
асуудлын хүрээний зорилт, чиг үүргийг
хэрэгжүүлэх стратегийн бодлого, төлөвлөлтийн
удирдамжаар хангахад цаг үеэ олсон зөвлөлгөө,
бүх талын дэмжлэг үзүүлэх;

2.5.2. Төрийн захиргааны удирдлага,
зохицуулалтын үйлчилгээ үзүүлэх;

2.5.3. Хүнс, хөдөө аж ахуйн салбарын
бодлогын хэрэгжилтийг зохицуулах;

2.5.4. Хүнс, хөдөө аж ахуйн салбарын хууль тогтоомж,бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үнэлгээ өгөх;

2.5.5. Мал эмнэлгийн үйлчилгээг сайжруулж мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах ажлыг зохион байгуулах;

2.5.6. Салбарын гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх.

2.6. Үйл ажиллагааны гол зорилт

Хүнс, хөдөө аж ахуйн яамны үйл ажиллагааны стратегийн зорилт тус бүрийн хүрээнд тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны дор дурдсан гол зориптыг дэвшүүлж ажиллана:

2.6.1. Үйл ажиллагааны стратегийн 1 дүгээр зорилтын хүрээнд:

2.6.1.1. Засгийн газрын бодлого, үйл ажиллагааны хөтөлбөрт нийцүүлэн хүнс, хөдөө аж ахуйн салбарын урт, дунд, богино хугацааны стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангахад мэргэшлийн зөвлөлгөө, дэмжлэг үзүүлж, хүнс, хөдөө аж ахуйн салбарын хууль тогтоомж, хөтөлбөр, төсөл боловсруулах;

2.6.1.2. Хүнс, хөдөө аж ахуйн салбарын сангийн үйл ажиллагаат зохицуулах;

2.6.1.3. Төсвийн ерөнхийлөн захирагчийн худалдан авах бүтээгдэхүүнтэй холбогдох бодлого, төлөвлөлт, тесвийн төсөл боловсруулах.

2.6.2. Үйл ажиллагааны стратегийн 2 дугаар зорилтын хүрээнд:

2.6.2.1. Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах;

2.6.2.2. Хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах;

2.6.2.3. Яамны хэвийн үйл ажиллагаа хангахад чиглэсэн дотоод үйлчилгээ, дэмжлэг үзүүлэх.

2.6.3. Үйл ажиллагааны стратегийн 3 дугаар зорилтын хүрээнд:

2.6.3.1. Мал аж ахуйн үйлдвэрлэлийг эрчимжүүлэх, үржлийн ажлын талаар төрөөс баримтлах бодлого болон малыг цаг агаарын гэнэтийн аюулаас хамгаалах бодлогыг зохицуулах;

2.6.3.2. Газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэх, техник, технологи, үрийн талаар явуулах бодлогын хэрэгжилтийг зохицуулах;

2.6.3.3. Хөдөө аж ахуйн эдэлбэр газрын болон бэлчээр ашиглалт, усан хангамжийн бодлогыг зохицуулах;

2.6.3.4. Хүн амын хүнсний хангамжийн бодлого, хүнсний хэрэглээний аюулгүй байдлыг хангах асуудлыг зохицуулах;

2.6.3.5. Мал, амьтан, ургамлын хорио цээр, хөнөөлт мэрэгч, хортонтой тэмцэх болон түүхий эд, бүтээгдэхүүний экспорт, импортыг дэмжих, зохицуулах;

2.6.3.6. Салбарын мэргэжилтнүүдийг мэдээлэл, арга зүйн удирдлагаар хангах.

2.6.4. Үйл ажиллагааны стратегийн 4 дугаар зорилтын хүрээнд:

2.6.4.1. Хүнс, хөдөө аж ахуйн салбарын хууль тогтоомж, бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл, хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх;

2.6.4.2. Салбарын мэдээллийн сүлжээ байгуулах, мэдээллийн сан бүрдүүлэх, хэрэглэгчдийг мэдээллээр хангах.

2.6.5. Үйл ажиллагааны стратегийн 5 дугаар зорилтын хүрээнд:

2.6.5.1. Мал, амьтны халдварт өвчний голомтыг устгах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх;

2.6.5.2. Мал эмнэлгийн мэдээ, судалгаа гаргах, бусад орон, олон улсын холбогдох байгуулагатай мэдээлэл солилцох, малын гоц халдварт өвчнөөр тайван орны жагсаалтад Монгол Улсыг бүртгүүлэх нөхцөлийг бүрдүүлэх;

2.6.5.3. Малын өвчний оношилгооны чадавхийг сайжруулж бэхжүүлэх;

2.6.5.4. Мал эмнэлгийн үйлчилгээний хүрээг өргөжүүлж, чанарыг сайжруулах, мал эмнэлгийн мэргэжилтнүүдийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах.

2.6.6. Үйл ажиллагааны стратегийн 6 дугаар зорилтын хүрээнд:

2.6.6.1. Гадаад орон, олон улсын байгууллагатай хамтын ажиллагаа өргөжүүлж,

албарт хөрөнгө оруулалтын таатай орчин үрдүүлэх;

2.6.6.2. Салбарт хэрэгжүүлж буй гадаадын өсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохицуулах, үр өлөөг дээшлүүлэх;

2.6.6.3. Сайдын гадаад айлчлалд үйлчилгээ зүүлэх, гадаадын зочид төлөөлөгчидтэй хамтран ажиллах, гэрээ хэлэлцээр хийхэд бүх талын эмжлэг үйлчилгээ үзүүлэх, протоколын арга эмжээг зохион байгуулах.

2.7. Үйл ажиллагааны зорилт

Хүнс, хөдөө аж ахуйн яамны үйл ажиллагааны гол зорилт тус бүрийн хүрээнд тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны зорилтыг тус яам тодорхойлж хэрэгжүүлнэ.

2.8. Үйл ажиллагааны стратегийн загвар

Хүнс, хөдөө аж ахуйн яамны үйл ажиллагаа /бизнес/-ны стратегийн загварыг дор дурдсанаар тодорхойлж байна:





3. Хүнс, хөдөө аж ахуйн яамны үйл ажиллагааны бүтцийн өөрчлөлт тогтолцоо, зохион байгуулалтын бүтэц, тэдгээрийн үндсэн үүрэг, чиг үүрэг

3.1. Бүтцийн өөрчлөлт тогтолцоо боловсруулахад баримталсан зарчим:

Хүнс, хөдөө аж ахуйн яамны үйл ажиллагааны бүтцийн өөрчлөлт тогтолцоо, зохион байгуулалтын бүтцийг боловсруулахад дор дурдсан зарчмыг баримтлав:

3.1.1. Засгийн газрын үйл ажиллагааны стратегитэй яамны үйл ажиллагааны стратегийг уялдуулсан байх зарчим;

3.1.2. Эрх мэдлийн зааг ялгаа нь тодорхой, итгэл хүлээхүйц байх зарчим;

3.1.3. Үзэгдэхүйц үйлчилгээний болон стратегийн удирдлагын баримжаатай байх зарчим;

3.1.4. Бүтцийн хувьд энгийн байх зарчим;

3.1.5. Тэнцвэрийг хангах, хяналтын хүрээг тогтоох зарчим;

3.1.6. Улс төрийн хувьд хараат бус байх зарчим;

3.1.7. Хангалттай чадавхи, бодитой үйл ажиллагааны зарчим.

3.2. Үйл ажиллагааны бүтцийн өөрчлөлт тогтолцооны загвар

Дээр дурдсан зарчим болон Хүнс, хөдөө аж ахуйн яамны үйл ажиллагаа /бизнес/-ны стратегийн загварыг үндэслэн тус яамны үйл ажиллагааны бүтцийн өөрчлөлт тогтолцооны загварыг дараахь байдлаар тогтоов:

3.3. Зохион байгуулалтын бүтэц

Хүнс, хөдөө аж ахуйн яамны үйл ажиллагааны стратегийн болон бүтцийн өөрчлөлтийг тогтолцооны загвараас тус яамны дор дурдсан зохион байгуулалтын бүтцийн нэгж гарч байна:

3.3.1. Стратегийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг:

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 1 дүгээр зорилтын хүрээнд Хүнс, хөдөө аж ахуйн сайдын эрхлэх асуудлын хүрээний бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл боловсруулах үндсэн үүргийг хүлээж хүнс, хөдөө аж ахуйн салбарын урт, дунд, богино хугацааны стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах, хөтөлбөр, төсөл, яамны үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөг боловсруулах, хүнс, хөдөө аж ахуйн тусгай зориулалтын сангуудын үйл ажиллагааг эрхлэх, төсвийн өөрчлөлтийг захирагчид нийлүүлэх бүтээгдэхүүний төлөвлөгөө, төсөв боловсруулах, хэрэгжүүлэх зэрэг чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь Хүнс, хөдөө аж ахуйн сайд, Засгийн газрын Танхимын үйл ажиллагааны үр нөлөө, үр ашгийг дээшлүүлэхэд чиглэнэ. Энэ нь Хүнс, хөдөө аж ахуйн сайдыг стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах, төсөв, сангийн үйл ажиллагаатай холбогдсон шийдвэр боловсруулан гаргах механизмд дэмжлэг үзүүлэх, шаардлагатай мэдээлэл, өгөгдөр мэргэшлийн, цаг үеэ олсон, шуурхай зөвлөлгөө, үйлчилгээ, бүх талын дэмжлэгээр хангах замаар хэрэгжинэ.

Нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Хүнс, хөдөө аж ахуйн сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь бусад яам, Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг, нутгийн захиргааны байгуллага, аж ахуйн нэгж болон хэвлэл, мэдээлэл, олон нийтийн байгууллага, иргэд байна. Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь Сангийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар байна.

3.3.2. Төрийн захиргааны удирдлагын асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 2 дугаар зорилтын хүрээнд төрийн захиргааны

удирдлагын болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, төрийн албан хаагчийн үйл ажиллагаг оновчтой зохион байгуулах, төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тогтолцоог хэрэгжүүлэх үндсэн үүргийг хүлээж, яамны үйл ажиллагааанд удирдлагын шилдэг арга барил, арга зүйг нэвтрүүлэх, хүний нөөцийн удирдлага, хөгжлийн асуудлыг шийдвэрлэх, ажлаа тайлагнах, хариуцлага тооцох тогтолцоог хөгжүүлэх зэрэг чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нь Хүнс, хөдөө аж ахуйн сайдад болон яамны аппаратад шийдвэр боловсруулан гаргах, хэрэгжүүлэхэд эрх зүйн болон дотоод үйлчилгээ үзүүлэх, шаардлагатай мэдээлэл, зөвлөлгөө, дэмжлэгээр хангах, байгууллагын соёл, чадавхийг дээшлүүлэх, тэргүүний арга барил, туршлагыг нэвтрүүлэх, төрийн захиргааны албан хаагчдыг сургаж хөгжүүлэх, тэдний үр дүнгийн гэрээ, мэргэшлийн түвшинг нь үнэлж дүгнэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгаат хангах замаар хэрэгжинэ. Үйлчилгээний ажлыг гэрээгээр гүйцэтгүүлэх үндсэн дээр яамны аппаратыг байр, холбоо, техник хэрэгсэл, шаардлагатай зүйлээр хангаж, ажиллах орчныг бүрдүүлнэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Хүнс, хөдөө аж ахуйн сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, төрийн захиргааны албан хаагчид байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь салбарын байгууллага, аж ахуйн нэгж, бусад хэрэглэгч байна. Үйлчилгээ үзүүлэхэд оролцох гол түнш нь Хууль зүй, дотоод хэргийн яам, Сангийн яам, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, боловсрол, сургалтын болон эрдэм шинжилгээний байгууллагууд байна.

3.3.3. Бодлогын хэрэгжилтийг зохицуулах асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 3 дугаар зорилтын хүрээнд хүнс, хөдөө аж ахуйн салбарын бодлогын хэрэгжилтийг зохицуулах үндсэн үүргийг хүлээж, энэ салбарт үйлчилж байгаа хууль тогтоомж, бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг зохицуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь Засгийн газар, Хүнс, хөдөө аж ахуйн сайдын бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, бодлого, төсөвтэй зохицуулалтын байдал, харилцан уялдаа холбоог хангахад чиглэнэ. Үр дүн нь бодит ажил хийгдсэн байна. Энэ нь төсөв, санхүүгийн болон бусад нөөцийг оновчтой хуваарилах замаар бодлого хэрэгжүүлэхэд оролцож байгаа бүх байгуллагатай харилцаа тогтоож, тэдний үйл ажиллагаар бодлого, төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглуулэн зохион байгуулах, зохицуулах замаар хэрэгжинэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Хүнс, хөдөө аж ахуйн сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, нуттийн захиргааны байгууллага байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь аж ахуйн нэгж, байгуллага, бусад хэрэглэгч байна. Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь Сангийн яам, Байгаль орчны яам болон бусад чиглэлийн яамд, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар байна.

3.3.4. Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 4 дүгээр зорилтын хүрээнд бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх болон бодлого боловсруулах, түүний хэрэжилтийн үр дүнг дээшлүүлэхэд чиглэгдсэн мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх үндсэн үүргийг хүлээж, хүнс, хөдөө аж ахуйн салбарын хууль тогтоомж, бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл, хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээрийн хэрэжилтийн явц байдалд хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, үйл ажиллагааны үр дүн, гэрээний үүргийн биелэлтийг тайлагнах тогтолцоог бүрдүүлэх, үр ашиг өгөөжийг дээшлүүлэх, нөөц илрүүлэх, ашиглахад чиглэгдсэн зөвлөмж, дэмжлэг үзүүлэх, орчин үеийн шинэ дэвшилтэт техник технологид тулгуурласан мэдээллийн найдвартай сүлжээ байгуулах, түүний хэвийн үйл ажиллагааг нь хангах, сүлжээний болон ажлын программ хангамжийн асуудлыг шийдвэрлэх, салбарын мэдээ, мэдээллийн төрөлжсөн сан байгуулах, мэдээ, мэдээллийн нээлттэй үйлчилгээг төлөвшүүлэх замаар яамны бодлого, үйл ажиллагааг олон нийтэд хүргэх, ил тод байдлыг хэвшүүлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь хүнс, хөдөө аж ахуйн салбарын бодлого боловсруулах, түүний хэрэгжилтийг зохицуулах, төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах үйл ажиллагаанд үр дүнг дээшлүүлэхэд чиглэнэ. Энэ нэгжийн үйл

ажиллагаа нь яамны бүтцийн нэгжүүд болон Бодлого боловсруулах, түүний хэрэгжилтийг зохицуулах, удирдан зохион байгуулах үйл ажиллагааны ролцож байгаа бүх байгуулгаа, удирдах, гүйцэтгэх албан тушаалтныг захиалсан мэдээ, мэдээллээр хангах, бодлого, үйл ажиллагааны хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнг үндэслэн гаргасан бодлого, зорилтын эцсийн үр дүнг дээшлүүлэхэд чиглэгдсэн зөвлөгөө, дэмжлэгийг цаг тухайд нь гүйцэтгэх замаар хэрэгжинэ.

Энэ нэгж нь яамны үйл ажиллагааны эцсийн үр дүнгийн талаар өөрийн үйл ажиллагаанд хийх бодит үнэлгээ, дүгнэлтийг хийх ба ажлын үр дүн нь бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл, хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээрийн ахиц дэвшил, үр өгөөжийг дээшлүүлэхэд оруулсан хувь нэмрээр тодорхойлогдоно.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн чиглэлэг нь Хүнс, хөдөө аж ахуйн сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, Засгийн газрын хэлтэс, агентлаг байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, бусад хэрэглэгч байна. Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь Сангийн яам, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Сангийн яам, эрдэм шинжилгээний байгууллага байна.

3.3.5. Мал эмнэлгийн асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн чиглэл, чиг үүрэг:

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 5 дугаар зорилтын хүрээнд мал, амьтны гоц халдварт өвчний голомтыг устгах, халдварт, паразиттаг өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах үндсэн үүргийг хүлээх, малын өвчний оношилгооны лабораторийн сайжруулж бэхжүүлэх, малын өвчний тархалтаар хяналт мэдээ, судалгааг нэгтгэн гаргах, бусад орон, олон улсын холбогдох байгуулагатай хамтран зохицуулах, малын гоц халдварт өвчнөөр хоногдсон статустай орон болох зорилтыг хэрэгжүүлэх, бусдыг захиргааны байгууллага, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, мал эмнэлэг, ариун цэврийн арга хэмжээ, малын эм бэлдмэлийн чанарыг хяналтаар шалгах, малын эмч, мэргэжилтний мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн, түүхий эдийн экспорт, импортын аюулгүй орчин бүрдүүлэхэд мал эмнэлгийн мэргэжил, арга зүйн дэмжлэг, туслалцаа үзүүлэхэд чиглэгдэнэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Хүнс, хөдөө аж ахуйн сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, мал бүхий иргэд, бусад хэрэглэгчид байна. Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь Сангийн яам, гамшгаас хамгаалах болон мэргэжлийн хяналтын төв байгууллага, мал эмнэлгийн сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн байгууллага байна.

3.3.6. Салбарын гадаад хамтын ажиллагааны асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг:

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 6 дугаар зорилтын хүрээнд хүнс, хөдөө аж ахуйн салбарын гадаад хамтын ажиллагаар өргөжүүлэн хөгжүүлэх үндсэн үүрэг хүлээх, гадаад орон, олон улсын байгууллагаас энэ салбарт оруулж буй хөрөнгө оруулалт, тусламж дэмжлэг, гадаадын төсөл, хөтөлбөрийн үр дүнг дээшлүүлэх, тэдгээрийн үялдаа холбоог зохицуулах үйл ажиллагаа эрхлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь олон улсын гэрээ, хэлцийн баримт бичиг боловсруулах, Засгийн газар хоорондын болон олон талын хэлэлцээрт оролцох асуудлыг зохицуулах, гадаад орон, олон улсын байгууллагад салбарын чиглэлээр санал тавьж, мэдээлэл өгөх зэрэг хэлбэрээр хэрэгжинэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Хүнс, хөдөө аж ахуйн сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, бусад хэрэглэгчид байна.

Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь Гадаад хэргийн яам, Сангийн яам, гадаадын хөтөлбөр, төслийн газар, олон улсын холбогдох байгуллага, гадаад орнуудаас Монгол Улсад суугаа Дипломат төлөөлөгчдийн газрууд байна.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 12 дугаар сарын 22-ны өдөр | Дугаар 244 | Улаанбаатар хот

Бичиг үсгийн боловсролын үндэсний хөтөлбөр батлах тухай

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 57 дугаар чуулганаар батлагдсан "Бичигтэн болох НҮБ-ын арван жил: Бүх нийтийн боловсрол 2003-2012 он" тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Бичиг үсгийн боловсролын үндэсний хөтөлбөр"-ийг хавсралт ёсоор батлагдсугай.

2. Хөтөлбөрийн зорилт, үйл ажиллагааны үндэсэн чиглэлийн дагуу түүнийг хэрэгжүүлэх ажлын дунд хугацаны төлөвлөгөөг 2005 оны I улиралд багтаан боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд П.Цагаанд даалгасугай.

3. Хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх жил бүрийн үндэсн чиглэл, төсөвт тусган санхүүжүүлэхийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд П.Цагаан, Сангийн сайд Н.Алтанхуяг, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

4. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүрийн I улиралд багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулж байхыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд П.Цагаанд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Ц.ЭЛБЭГДОРЖ

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД П.ЦАГААН

Засгийн газрын 2004 оны 244 дүгээр тогтоолын хавсралт

БИЧИГ ҮСГИЙН БОЛОВСРОЛЫН ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

Монгол Улс зах зээлийн эдийн засгийн тогтолцоо бүхий хүний эрхийг бүх талаар дэмжлэгтэй ардчилсан, иргэний нийгмийн хөгжлийн замыг сонгон авснаас хойш сүүлийн арав гаруй жилийн хугацаанд хүний сайн сайхан амьдралын суурь нөхцөлийн нэг болсон бүх нийтийн боловсролын салбарт тодорхой үр дүнд хүрсэн билээ.

2000 оны хүн ам, орон сууцны тооллогоор насанд хүрэгчдийн 2.2 хувь буюу 34011 хүн бичиг үсэг мэдэхгүй байсан бол 2003 оны 12 дугаар сарын байдлаар 13999 болж 41 хувиар буурч, суурь боловсролын хамран сургалтын цэвэр жин 90.4 хувьд хүрч 2000 оны түвшингээс 3.9 хувиар өссөний зэрэгцэх сургууль завсардалт сүүлийн 12 жилийн хугацаанд 8.8 хувиас 2.2 хувьд хүртэл эрс буурч байгаа нь бүх нийтийн боловсрол эзэмших эрхийг хангах, бүх нийтэд суурь боловсрол эзэмшүүлэх талаар Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа олон талт, шат дараалсан арга хэмжээний бодит үр дүн болсон байна.

Статистикийн мэдээ, судалгааны үр дүнгээс авч үзвэл:

-хэдийгээр манай орны хувьд бусад хөгжиж буй орнуудтай харьцуулахад бичиг үсгийн боловсролын асуудал бүх нийтийг хамарсан томоохон асуудал биш боловч хүн амын дунд бичиг үсэг үл мэдэгчид, суурь боловсрол эзэмшээгүй хүүхдүүд байсаар байна.

-бичиг үсэг үл мэдэгчид, сургууль завсардсан хүүхэд, залуучуудын ихэнх нь орлого багатай айл өрхөд ногдож байгаа бөгөөд хөдөлмөр зохицуулалтын албанд бүртгүүлэхгүй ажил идэвхтэй

:айж байгаа хүмүүсийн 60-аас дээш хувь нь ıэргэжил, боловсролгүй хүмүүс байна.

-1990-ээд оны эхээр мал аж ахуйг :увьчилаж явцад эцэг, эхдээ туслах зорилгоор ıрэгтэй хүүхэд олноороо сургуулиас гарч, мал ıаллан сургууль завсардсаны сөрөг үр дагавар ıнөөдөр ч хадгалагдсаар байна.

-2003 оны байдлаар насанд хүрсэн бичиг ıсэг үл мэдэгчдийн тоо хөдөө орон нутагт хотоос ıурав дахин их байгаа бөгөөд сургууль завсардсан ıүүхдийн 75.8 хувь нь хөдөөд ногдож байна.

-сүүлийн жилүүдэд хотод шилжин ирэх ıөделгөөн ихэссэнгүй улмаас сургуулиудын хүчин ıадал хүрэлцээгүйгээс сургууль завсардах үзэгдэл ıжиглагдах боллоо.

Манай улсын хүн амын бичиг үсгийн ›оловсролын өнөөгийн нөхцөл байдал нь хүн ›үрийн боловсролд зээмших эрхийг хангах, хүйсийн ıэдрэмжтэй, тэгш хамруулан суралцуулах нөхцөлийг хангасан боловсролын үйлчилгээний ›үртээмжийг өргөжүүлэх замаар бичиг үсгийн ›оловсролыг бүх нийтэд заавал эзэмшүүлэхэд ıиглэгдсэн төрийн бодлогыг эрчимжүүлэх ıаардлагатай байгааг илэрхийлж байна.

Бичиг үсэг үл мэдэх явдлыг устгах төрийн ›одлогыг эрчимжүүлэх нь:

-хүний хөгжлийг дэмжих замаар ядуурал, ıжилгүйдлийг бууруулах, хот, хөдөөгийн ялгааг ›рилгах, эдийн засгийн өсөлт, тогтвортой хөгжлийг ıангах суурь нөхцөлийг бий болгоно гэдгийг ıндэслэж,

-бичиг үсэгт тайлагдаагүй иргэдийг бичиг ıэгт сургах, боловсрол нөхөн эзэмших боломжийг ıь хангах үндсэн дээр тэдний иргэний, улс төр, ıийгэм, эдийн засаг, соёлын үндсэн эрх, эрх чөлөөг ›үрэн, адил тэгшээр хангах нөхцөлийг бий болгохыг ›рмэлзэж,

-соёл, боловсрол, нийгэм, эдийн засаг, улс ›ийн бүхий л хаалцаанд хүйсийн тэгш байдлыг ıангах, иргэд, олон нийтийн оролцоог ıдэвхижүүлэх, ардчиллыг бэхжүүлэх, иргэдийн ıасан туршдаа суралцах үндсэн эх сурвалж мөн ›дгийг иш үндэс болгож,

-эх, нялхсын болон хүүхдийн эндэгдлийг бууруулах, ДОХ, амьсгалын замын цочмог халдварт өвчин зэрэг нийгэм, хүн ардад нэн аюултай халдварт өвчнүүдээс урьдчилан сэргийлэх болон хувиараа хөдөлмөр эрхлэх, үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, нийгмийн эрүүл сэтгэлгээнд тулгуурлан аж төрөх, амьдрах гэх мэт хүн амын амьдрах ухаан, амьжиргааны чадварыг бэхжүүлэхэд бичиг үсгийн боловсрол чухал нөлөөтэйг онцлон тэмдэглэж,

-Монгол Улсын Засгийн газар дэлхий нийтээр бичигтэн болох дэлхий дахины хөдөлгөөнийг санаачлагч орны хувьд өөрийн орны үлгэрлэн манлайлах үүргээ хэрэгжүүлж байгаагийн нэг тод илэрхийлэл гэдгийг нотолж,

-НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 57 дугаар чуулганаар батлсан "Бичигтэн болох НҮБ-ын арван жил: Бүх нийтийн боловсрол 2003-2012 он" тогтоол, 2000 онд дэлхийн дээд хэмжээний чуулга уулзалтаар батлсан "Мянганы хөгжлийн зорилтууд", 2000 оны Дэлхийн боловсролын дээд хэмжээний чуулга уулзалтаар батлсан "Бүх нийтийн боловсролын Дакарын үйл ажиллагааны хүрээ"-нд заасан зорилтуудад хүрэхийн төлөө Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж байгаа үүрэг хариуцлага, хүчин чармайлтын нэгэн тод бодит алхам болгож,

Монгол Улсын Засгийн газраас "Бичиг үсгийн боловсролын үндэсний хөтөлбөр"-ийг баталж байна.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго

Хүн бүрийг адил тэгшээр хамруулан суралцуулах нөхцөлийг хангасан, хүйсийн мэдрэмжтэй, олон нийтийн оролцоо, нийгмийн түншлэлд тулгуурласан бичиг үсгийн боловсролын үйлчилгээний хүртээмж, чанар, үр ашгийг өргөжүүлэх замаар:

-нэн тэргүүнд хүн амын дунд бичиг үсэг үл мэдэх явдлыг устгах,

-сургууль завсардсан хүүхдүүдэд бичиг үсгийн боловсролыг нөхөн эзэмшүүлэх,

-сургууль завсардалтаас урьдчилан сэргийлэх, бүх нийтэд бичиг үсгийн боловсролыг

Эрүүл мэндийн яамны үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгч нь Эрүүл мэндийн сайд, Засийн газрын Танхим байна. Эрүүл мэндийн яамны бодлого, удирдлага, зохицуулалт нь дээр дурдсан хэрэгцээний эх үүсвэр, алангуяа үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгчийн эрэлт хэрэгцээг хангахтай холбогдон үүсэх харилцаат зохицуулахад чиглэнэ. Эрүүл мэндийн яамны стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээг хангах үйлчилгээний хүрээ, төрөл, хэлбэрийг хэрэгцээний эх үүсвэр тус бүрээр тогтоон тус яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн зорилт, чиг үүргийг төрийн албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтод нарийвчлан тусгаж хэрэгжүүлнэ.

2. Эрүүл мэндийн яамны үйл ажиллагааны стратеги

2.1. Үйл ажиллагааны стратегийн мөн чанар

Эрүүл мэндийн яамны үйл ажиллагааны стратегийн мөн чанар нь Засгийн газрын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэсэн Эрүүл мэндийн сайдын үйл ажиллагааг өндөр мэргэшлийн, цаг үеэ олсон, шуурхай зөвлөлгөө, бүх талын дэмжлэг үзүүлэхэд оршино.

2.2. Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл

Эрүүл мэндийн яам нь дор дурдсан үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлтэй ажиллана:

2.2.1. Эрүүл мэндийн яамны үйл ажиллагааны үр нөлөө, үр ашгийг дээшлүүлэх, Эрүүл мэндийн сайд, Засгийн газрын Танхимд үзүүлэх зөвлөлгөө, үйлчилгээ, дэмжлэгийг сайжруулах;

2.2.2. Эрүүл мэндийн салбарын удирдлагын чадавхийг нэмэгдүүлэх, бүтэц, үйл ажиллагааг өөрчлөн боловсронгуй болгох;

2.2.3. Улсын болон хувийн хэвшлийн зохистой харьцаа тогтоох, хувийн хэвшлийг бүх талаар дэмжин хөгжүүлэх;

2.2.4. Эрүүл мэндийн тусламжийг хүн амд жигд хүргэх, ниймийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, нөөцийг тэгш хуваарилах чадавхийг бүрдүүлэх.

2.3. Эрхэм зорилго

Эрүүл мэндийн яамны үйл ажиллагааны эрхэм зорилго нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, урьдчилан сэргийлэх ажлын чанарыг олон улсын [illegible] амьдрах сайн сайхан нөхцөлийг бүрдүүлэх явдал мөн. [illegible]

2.4. [illegible]

Эрүүгэрэ[illegible] хүрээнд үйл ажиллагаа[illegible] зорилтыг хэрэг[illegible]

2.4.1[illegible] удирдлага, [illegible] цаг үеэ олсоо[illegible]

2.4.[illegible] манлайлалыг [illegible] хэрэгжилтэд [illegible] бүрдүүлэх; [illegible]

2.4.[illegible] удирдлага, [illegible]

2.4.[illegible] түүний хэрэгжилт[illegible]

2.4.[illegible] салбарын б[illegible]

2.4.[illegible] хэрэгжилтэд [illegible] үнэлгээ [illegible]

2.4.[illegible] хөгжүүлэх [illegible]

2.5.[illegible] зорилтын хүн[illegible]

2.5.[illegible] удирдлагаа[illegible]

2.5.[illegible] хуваарилал[illegible]

2.5.[illegible] бүртгэлийн [illegible]

2.5.[illegible] хэрэгцээнд [illegible]

2.5.[illegible] зорилтын [illegible]

2.5.[illegible] манлайлалы[illegible] боловсруулах [illegible] дэмжлэг [illegible]

стандардаар, аргжетингийн
эйхан аппаратыг
сайд бол
зөвлөлтөй
тэмжлэгээр

Үйл ажлыг
лбан хан
ыг сургаж
үл мэнд
иллагаа, эргэшлийн
ажиллагаа
ргэгчүүдийг
хүний нөөц
оновчтой
1. Эрүүл мэндийн
төлөвлөлтийг
надахь хөгжүүлэх,
он эрүүл мэндийн
ны стратегийн 3 дугаар
2. Төрөөгүй хүүхдийн
ыг хүчтэй
д хяналтыг
мэндийн
тусламж,
хүргүүлэх;
3. Эмнэлгийн
ттийн эрүүл мэндийн
чанарыг
оновсроно
болгох,
н тоног
төхөөрөмжөөр
4. Эрүүл мэндийн
ажилтнуудыг
тусламжий
удирдлага,
5. Эмчлэгдэ
ийн зохиц
харьцаат
одлогоны
мэнэлгийн
6. Хүн амын
ийнхний
удад оно
д хяналтыг
мэнэлгийн
ох;
эрүүлэх
7. Гадаадын
ны стратегийн 4 дүгээр
Үйл ажлыг
ийн салбарт
бодлого,
хөгжүүлэх
1. Үйлдвэрлэ
эрүүлэх,
ргэгчдийг
ангах, уялдаа
холбоог
1.1. Хүн амын
ан эрүүл мэндийн
эр хяналтыг
гуулалт, мэдээллийн
болгох, сангүйжилтийн
1.1.2.
лтыг зохицуулах
ийн салбарт
зүгээс хүн
1.1.3. Эрүүл
рүүл мэндийн чанар,
н зохицуулалтыг
1.1.4. Эрүүл мэндийн
ога хэмжээний салбар
ий статистикийн
ог шинжээгээ бүтээ,
дүнгээр нэвтэх, бусад
ийн
ийн нийгмийн
ог нэмэгдүүлэх.
1.2. Үйлдвэрлэ
хүрээнд
ны стратегийн 5 дугаар
2.1.1. Эрүүл
ыг хяналтаа
ийн удирдлага, зохион
улан
зүүлэхэхэхэхэхэхэхэхэхэхэхэхэхэхэ
болгох;

2.5.5.2. Зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн хангамжийг тасралтгүй, жигд, хүртээмжтэй байлгахад чиглэсэн арга хэмжээг оновчтой зохион байгуулах;

2.5.5.3. Эмчилгээний практикт хэрэглэх эмийн ашуулгүй байдал, чанарын баталгаажилтыг хангах;

2.5.5.4. Эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх.

2.5.6. Үйл ажиллагааны стратегийн 6 дугаар зорилтын хүрээнд:

2.5.6.1. Хүн амын эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үнэлгээ өгөх, асуудал дэвшүүлэх;

2.5.6.2. Эрүүл мэндийн эрэлт хэрэгцээ, нөөцийн байдалд хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөх;

2.5.6.3. Эдийн засаг, санхүүгийн мэдээлэл цуглуулах, боловсруулах, үнэлгээ хийх, түгээх;

2.5.6.4. Салбарын хөгжлийн бодлого, түүний үр дүнд дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх;

2.5.6.5. Удирдлагын шийдвэр гаргах түвшинд эрүүл мэндийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх, мэдээллийн сүлжээ, сан байгуулах, программ хангамжаар үйлчлэх.

2.5.7. Үйл ажиллагааны стратегийн 7 дугаар зорилтын хүрээнд:

2.5.7.1. Гадаад харилцаа, хамтын ажиллагааг Эрүүл мэндийн яамны стратеги, бодлоготой нягт уялдуулан бэхжүүлэх;

2.5.7.2. Эрүүл мэндийн салбарт хандивлагчдын дэмжлэгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулахад бүх талын туслалцаа үзүүлэх;

2.5.7.3. Эрүүл мэндийн салбарт гадаадын хөрөнгө оруулалтын үр өгөөжийг дээшлүүлэх.

2.6. Үйл ажиллагааны зорилт

Эрүүл мэндийн яамны үйл ажиллагааны гол зорилт тус бүрийн хүрээнд тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны зорилтыг тус яам тодорхойлж хэрэгжүүлнэ.

2.7. Үйл ажиллагааны стратегийн загвар

Эрүүл мэндийн яамны үйл ажиллагаа (бизнес)-ны стратегийн загварыг дор дурдсанаар тодорхойлж байна:



3. Эрүүл мэндийн яамны үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо, санал болгож буй зохион байгуулалтын бүтэц, тэдгээрийн үүрэг, чиг үүрэг

3.1. Бүтцийн ерөнхий тогтолцоо боловсруулахад баримтлах зарчим

Эрүүл мэндийн яамны үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо, санал болгож буй

зохион байгуулалтын бүтцийг боловсруулахад дор дурдсан зарчим баримтлав:

а/Засгийн газрын үйл ажиллагааны стратегитай тухайн яамны стратегийн зорилтыг уялдуулах зарчим;

б/эрх үүргийн ялгаа, заг нь тодорхой, итгэл хүлээхүйц байх зарчим;

в/үзэгдэхүйц үйлчилгээний болон стратегийн удирдлагын баримжаатай байх зарчим;

г/бүтцийн хувьд энгийн байх зарчим;

д/тэнцвэрийг хангах, хяналтын хүрээг тогтоох зарчим;

е/улс төрийн хувьд төвийг сахисан байх зарчим;

ж/хангалттай чадавхи, бодитой үйл ажиллагааны зарчим.

3.2. Үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар

Эрүүл мэндийн яамны үйл ажиллагаа (бизнес)-ны стратегийн загварыг үндэслэн тус яамны үйл ажиллагааны бүтцийн дор дурдсан ерөнхий тогтолцооны загварыг санал болгож байна:



3.3. Зохион байгуулалтын бүтэц

Эрүүл мэндийн яамны үйл ажиллагаа (бизнес)-ны стратегийн болон бүтцийн ерөнхий тогтолцооны загвараас тус яамны дор дурдсан зохион байгуулалтын бүтцийн нэгж гарч байна:

3.3.1. Санхүү, эдийн засгийн удирдлага, төлөвлөлтийн зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 1 дүгээр зорилтын хүрээнд эрүүл мэндийн салбарын бодлого, тэргүүлэх чиглэл, үйл ажиллагаг дэмжсэн эдийн засаг, санхүүгийн уян хатан тогтолцоог бүрдүүлэх, эрүүл мэндийн удирдлага, санхүүгийн төлөвлөлт, хуваарилалт, бүртгэл, хяналт, зохицуулалтыг хангахад мэргэжлийн зөвлөлгөө өгөх, эдийн засгийн үнэлгээ хийх, дэмжлэг үзүүлэх зэрэг үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь Эрүүл мэндийн сайд, Засгийн газрын Танхимийн үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэхэд чиглэнэ. Энэ нь Эрүүл мэндийн сайдыг эрүүл мэндийн салбарын санхүү, эдийн засгийн удирдлага, төлөвлөлтийн удирдамжаар хангахтай холбогдсон шийдвэр боловсруулан гаргах механизмд дэмжлэг үзүүлэх, Засгийн газрын гишүүн, Эрүүл мэндийн сайдыг шаардлагатай мэдээлэл, өгөдөр мэргэжлийн, цаг үеэ олсон шуурхай зөвлөлгөө, үйлчилгээ, бүх талын дэмжлэгээр хангах замаар хэрэгжинэ. Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Эрүүл мэндийн сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь бусад яам, Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг, нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж болон хэвлэл мэдээлэл, олон нийтийн байгууллага, иргэд болно. Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Сангийн яам,

Гадаад хэргийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам байна.

3.3.2. Төрийн захиргааны удирдлагын асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 2 дугаар зорилтын хүрээнд төрийн захиргааны удирдлагын болон хүний нөөцийг хөгжүүлэх, манлайллыг хангах үндсэн үүргийг хүлээж, яамны үйл ажиллагаанд удирдлагын шилдэг тэргүүний туршлага, арга зүйг нэвтрүүлэх, хүний нөөцийн удирдлага, хөгжлийн асуудлыг шийдвэрлэх, ажлаа тайлагнах, хариуцлага тооцох тогтолцоог бэхжүүлэх, хэвлэл, мэдээлэл, сурталчилгааны ажлыг зохион байгуулах, захидал, өргөдөл, гомдлыг барагдуулах чиг үүрэгийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь цомхон, чадварлаг төрийн албан хаагч бүхий төрийн захиргааны мэргэшсэн албаны хүчээр яамны тасралттүй, хэвийн жигд ажиллагааг хангахад чиглэнэ.

Эрүүл мэндийн сайдад болон яамны аппаратад шийдвэр боловсруулан гаргах, хэрэгжүүлэхэд эрх зүйн болон дотоод үйлчилгээ үзүүлэх, шаардлагатай мэдээлэл, зөвлөлгөө, дэмжлэгээр хангах, салбарын нэгж, хэсгийн удирдлагын менежмент, маркетингийн чадавхийг дээшлүүлэх, хүний нөөцийн хөгжлийг хангах, төрийн албан хаагчдыг сургаж хөгжүүлэх, тэдний үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг нь үнэлж дүгнэх, ажиллах нөхцөл, ниймийн баталгаат хангах замаар хэрэгжинэ. Энэ нэгжийн бүтцэд аппаратын аж ахуй, үйлчилгээ, санхүүгийн үйл ажиллагаа хамаарна.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Эрүүл мэндийн сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь Засгийн газрын тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлаг, төсөвт байгууллага, аж ахуйн нэгж, иргэд, бусад хэрэглэгч байна. Үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Сангийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам. Гадаад хэргийн яам, боловсрол, сургалт, эрдэм шинжилгээний байгууллага байна.

3.3.3. Эмнэлгийн тусламжийн асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 3 дугаар зорилтын хүрээнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний бодлогыг хэрэгжүүлэх, эмнэлгүүдийн удирдлагын чадавхи (менежмент)-ийг сайжруулах орон нутгийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг боловсронгүй болгох, орчин үеийн тоног төхөөрөмжөөр хангах, оношилгоо эмчилгээний төвийг бүсчлэн байгуулж, үйлчлэх хүрээг өргөтгөх, эмнэлгийн тусламжийн чанар, хүртээмж, үйлчилгээг сайжруулах, мэргэжлийн удирдлагаар хангаж дэмжлэг үзүүлэх үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь Эрүүл мэндийн сайдын бодлого, шийдвэрийн хэрэгжилт, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт эмнэлгийн тусламжийн талаар дэвшүүлсэн зорилт, төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглүүлэн зохион байгуулах замаар хэрэгжинэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Эрүүл мэндийн сайд, удирдлага, Засгийн газрын холбогдох тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг, нутгийн захиргааны байгууллага, иргэд байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг эрүүл мэндийн төсөвт байгууллага, аж ахуйн нэгж, бусад хэрэглэгч авч болно. Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол тал нь эрүүл мэндийн байгууллагууд, Сангийн яам, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, олон улсын байгууллага болон төрийн бус зарим байгууллага байна.

3.3.4. Эрүүл мэндийн бодлого, зохицуулалт эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь стратегийн 4 дүгээр зорилтын хүрээнд бодлого, төсөл, хөтөлбөр боловсруулах, түүний тэнцвэрт байдал, харилцан уялдаа холбоог хангах, Засгийн газар, Эрүүл мэндийн сайдын бодлого, шийдвэрийн хэрэгжилт, хүн амын эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, ниймийн эрүүл мэндийн үйлчилгээг зохицуулах, зохион байгуулан хэрэгжүүлэхэд чиглэнэ. Энэ нь ниймийн эрүүл мэндийн болон бусад нөөцийг оновчтой хуваарилах замаар бодлого хэрэгжүүлэхэд оролцож байгаа бүх байгууллагатай түншийн харилцаа тогтоож, тэдний үйл ажиллагаа, бодлого, төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд

чиглүүлэн зохион байгуулах, зохицуулах замаар хэрэгжинэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Эрүүл мэндийн сайд, дэд сайд, Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг, нутгийн захиргааны байгууллага байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь эрүүл мэндийн төсөвт байгууллага, улсын үйлдвэрийн газар, аж ахуйн нэгж, иргэд болон бусад хэрэглэгч байна. Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол тал нь Сангийн яам, төрийн бус зарим байгууллага байна.

3.3.5. Эм, эмнэлгийн хэрэгслийн асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 5 дугаар зорилтын хүрээнд эмийн талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх, эм хангамжийн удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хангамжийг тасралтгүй, жигд, хүртээмжтэй байлгахад чиглэсэн арга хэмжээг оновчтой зохион байгуулах, эмчилгээний практикт хэрэглэх эмийн аюулгүй байдал, чанарын баталгаажилтыг хангах, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэхэд чиглэгдэнэ. Энэ нь шийдвэр гаргах, бодлого боловсруулах түвшний удирдлага, нэгж болон бусад хэрэглэгчид, байгууллагуудыг эмийн талаар үнэн зөв мэдээллээр шуурхай хангах, мансуурах, сэтгэц нөлөөт эмийн эргэлтийг олон улсын конвенц, холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулах замаар хэрэгжинэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Эрүүл мэндийн сайд, дэд сайд, Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг, нутгийн захиргааны байгууллага байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь эрүүл мэндийн төсөвт байгууллага, улсын үйлдвэрийн газар, аж ахуйн нэгж, иргэд болон бусад хэрэглэгч байна. Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол тал нь Сангийн яам, Хүнс, хөдөө аж ахуйн яам, төрийн бус зарим байгууллага байна.

3.3.6. Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 6 дугаар зорилтын хүрээнд бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ (мониторинг) хийх, үнэлгээ өгөх үндсэн үүрэгтэй хүлээж, эрүүл мэндийн бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл, норм, норматив, стандартын хэрэгжилтийн явц байдалд хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, мэдээллийн сүлжээ, сан бүрдүүлж, мэдээллийн технологиор үйлчлэх үндсэн чиг үүрэгийг хэрэгжүүлнэ.

Энэ нь бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төслийн хэрэгжилт, үр дүнд үнэлгээ өгөх замаар яамны бүтцийн нэгжүүдийн болон бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд оролцож байгаа бүх байгууллага, тэдгээрийн удирдах, гүйцэтгэх албан тушаалтны үйл ажиллагаг сайжруулахад чиглэсэн зөвлөгөө, дэмжлэгээр цаг тухайд нь хангах замаар хэрэгжинэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Эрүүл мэндийн сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг байх бөгөөд энэ үйлчилгээг шууд бус хэлбэрээр хэрэглэгч нь төсөвт байгууллага, аж ахуйн нэгж, иргэд, бусад хэрэглэгч байна. Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол тал нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, сургалт, эрдэм шинжилгээний байгууллага байна.

3.3.7. Гадаад харилцаа, хамтын ажиллагааны асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 7 дугаар зорилтын хүрээнд хамтын ажиллагаг Эрүүл мэндийн яамны стратеги бодлоготой нягт уялдуулан бэхжүүлэх, эрүүл мэндийн салбарт хандивлагчдын дэмжлэгийг нэмэгдүүлэх, мөн гадаадын хөрөнгө оруулалтын үр өгөөжийг дээшлүүлэх, олон улсын байгууллага болон гадаад орнуудтай эрүүл мэндийн талаар хамтран ажиллах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Эрүүл мэндийн сайд, дэд сайд, удирдлага, аппаратын ажиллагсад, Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг, олон улсын байгууллага, шууд харилцаат улс орнууд болон бусад хэрэглэгч тал нь Гадаад хэргийн яам, Сангийн яам, төрийн бус байгууллага байна.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 12 дугаар сарын 8-ны өдөр | Дугаар 237 | Улаанбаатар хот

Сүлжмэл эдлэл, оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн тогтвортой ажиллагааг хангах зарим арга хэмжээний тухай

Сүлжмэл эдлэл, оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн салбарт гарч байгаа хүндрэлийг арилгах, тогтвортой ажиллагааг хангах зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Нийгмийн даатгалын шимтгэл болон татварын бодлогын шинэчлэлийн арга хэмжээнд сүлжмэл, оёмол бүтээгдэхүүний салбарыг хамруулж холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулах, оёмол бүтээгдэхүүний дотоодын захиалга, хэрэглээг нэмэгдүүлэх, ажилчдыг шинээр мэргэшүүлэх, мэргэжлийн дагуу гадаадын хөдөлмөрийн зах зээлд зуучлах зэрэг арга хэмжээ авахыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Ц.Баярсайхан, Сангийн сайд Н.Алтанхуяг, Үйлдвэр, худалдааны сайд С.Батболд, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд П.Цагаан нарт даалгасугай.

2. Сүлжмэл эдлэл, оёмол бүтээгдэхүүний гадаад зах зээлийг өргөжүүлэх, худалдааны хөнгөлөлтийн өөрөөсөй системд хамруулах талаар ОХУ, Европын Холбоо болон бусад оронтой хоёр болон олон талын яриа, хэлэлцээг идэвхжүүлэх, тус салбарын технологийг шинэчлэх, ажиллагсдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр гадаад хамтын ажиллагааны хүрээнд хөтөлбөр, төсөлд хамруулан дэмжих арга хэмжээ авч ажиллахыг Үйлдвэр, худалдааны сайд С.Батболд, Гадаад хэргийн сайд Ц.Мөнх-Оргил, Сангийн сайд Н.Алтанхуяг нарт даалгасугай.

3. Төсвийн болон орон нутгийн өмчөөр бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээ худалдан авахдаа дотоодын үйлдвэрүүдийн бүтээгдэхүүнийг тэргүүн ээлжинд сонгох, захиалгат бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх арга хэмжээ авч дэмжлэг үзүүлж байхыг Сангийн сайд Н.Алтанхуяг, Батлан хамгаалахын сайд Б.Эрдэнэбат, Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд П.Цагаан нарт даалгасугай.

4. Үйлдвэрлэл, технологийн парк байгуулах бодлогын хүрээнд сүлжмэл эдлэл, оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэгчдийг дэмжих боломжийг судалж хэрэгжүүлэх санал боловсруулж 2005 оны Шүлирлд багтаан Засгийн газрын хуралдаванаар хэлэлцүүлэхийг Үйлдвэр, худалдааны сайд С. Батболдод үүрэг болгосугай.

5. Бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, технологийн шинэчлэлт хийх, ажиллагчдынхаа мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, тэдэнд хос мэргэжил эзэмшүүлэх замаар хөнгөн үйлдвэрлэлийн бусад салбарт хөрвөн ажиллах боломжийг бүрдүүлэх, БНХАУ болон бусад орны оёмол бүтээгдэхүүн үйлдвэрлэгчидтэй тодорхой бүтээгдэхүүний бэлдэц, иж бүрдлийн хэсгээр дагнах, хорших чиглэлээр хамтран ажиллах талаар идэвхтэй үйл ажиллагаа явуулахыг сүлжмэл эдлэл, оёмол бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид болон Монголын оёмол бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн холбооны тэргүүн Н.Даш-Өлзийд зөвлөсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Ц.ЭЛБЭГДОРЖ

ҮЙЛДВЭР, ХУДАЛДААНЫ САЙД С.БАТБОЛД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 12 дугаар сарын 15-ны өдөр **Дугаар 238** **Улаанбаатар хот**

Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2004 оны 7 дугаар сарын 29-ний өдрийн 163 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Тэмдэглэлт өдрүүдийн жагсаалт"-д "47.Газрын харилцааны ажилтны өдөр-5 дугаар сарын эхний Ням гараг." гэж нэмсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Ц.ЭЛБЭГДОРЖ

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД Н.БАТБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 12 дугаар сарын 15-ны өдөр **Дугаар 239** **Улаанбаатар хот**

Төрийн өмчийн хорооны зарим гишүүнийг томилох, чөлөөлөх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Төрийн өмчийн хорооны гишүүнээр дор дурдсан хүмүүсийг томилсугай:

-Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Цэрэндорж;

-Түлш, эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Цэрэнпүрэв;

-Хүнс, хөдөө аж ахуйн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Батсуурь;

-Зам, тээвэр, аялал жуулчлалын яамны Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга Ц.Маналжав;

-Үйлдвэр, худалдааны яамны Геологи, уул уурхайн бодлого зохицуулалтын газрын дарга Д.Галсандорж;

-Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газрын Бодлогын хэрэгжилт, зохицуулалтын хэлтсийн дарга А.Мөнхбат.

2. Төрийн өмчийн хорооны гишүүнээр өмнө нь ажиллаж байсан Г.Цэндсугар, Ж.Хатанбаатар, Ц.Базар, Ш.Сономдагва, Д.Баярсайхан, А.Баасанжав, Я.Пүрвээ, Ч.Хүрэлбаатар нарыг Төрийн өмчийн хорооны гишүүнээс тус тус чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Ц.ЭЛБЭГДОРЖ

САНГИЙН САЙД Н.АЛТАНХУЯГ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 12 дугаар сарын 20-ны өдөр **Дугаар 241** **Улаанбаатар хот**

Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн өөрчлөгдсөнтэй холбогдуулан Япон Улсын Айчи мужид зохиогдох "ЭКСПО-2005" дэлхийн үзэсгэлэнд Монгол Улсыг оролцуулах бэлтгэлийг хангах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэх шаардлагатай болсон тул "Ажлын хэсэг байгуулах тухай" Засгийн газрын 2002 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн 65 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Ц. ЭЛБЭГДОРЖ

ҮЙЛДВЭР, ХУДАЛДААНЫ САЙД С. БАТБОЛД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 12 дугаар сарын 21-ний өдөр **Дугаар 242** **Улаанбаатар хот**

Сангийн яамны зохион байгуулалтын бүтцийг батлах тухай

Засгийн газрын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 3 дахь заалт, Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 10.1-ийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Сангийн яамны зохион байгуулалтын бүтцийг дор дурдсанаар шинэчлэн батлсугай:

1/Эдийн засгийн нэгдсэн бодлогын газар;

2/Салбарын бодлого, хөрөнгө оруулалтын газар;

3/Төсвийн бодлого, зохицуулалтын газар (зарлагын хэлтэс, орлогын хэлтэс, төсвийн нэгтгэлийн хэлтэстэй);

4/Төрийн захиргааны удирдлагын газар (захиргаа, хуулийн хэлтэс, мэдээллийн технологийн хэлтэс, хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэстэй);

5/Төрийн сангийн газар (санхүүжилт, тайлан, бүртгэлийн хэлтэс, өрийн удирдлагын хэлтэс, төлбөр тооцооны хэлтэстэй);

6/Зээл, тусламжийн нэгдсэн бодлого, зохицуулалтын газар;

7/Худалдан авах ажиллагааны бодлого, зохицуулалтын газар;

8/Нягтлан бодох бүртгэлийн бодлого, арга зүйн хэлтэс.

2. Сангийн яамны орон тооны хязгаарыг 121, зардлын төсвийн хязгаарыг 772328.9 (долоон зуун далан хоёр сая гурван зуун хорин найман мянга есөн зуун) мянган төгрөг, цалингийн сангийн хязгаарыг 178844.3 (нэг зуун далан найман сая найман зуун дөчин дөрвөн мянга гурван зуун) мянган төгрөгөөр тогтоосугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Яамдын зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн батлах тухай" Засгийн газрын 2003 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн 43 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн 1.2 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Ц.ЭЛБЭГДОРЖ

САНГИЙН САЙД Н.АЛТАНХУЯГ

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
"Төрийн Мэдээлэл" эмхтгэлийн эвлэл
Улаанбаатар- 12.
Төрийн ордон
☎ 329612 Индекс 14003

Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэг хэвлэв.
☎ 329487
Хэвлэлийн хуудас 4